ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
**МОНГОЛ УЛСЫН ДАЛАЙН ЗАХИРГАА**

Лагшан төв, С.Амарын гудамж, Ерөнхий сайд, 8 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200
Утас: 26 14 89, 26 14 90, Факс: (976-11)-31 06 42
Цахим шуудан: info@monmarad.gov.mn
Цахим хуудас: www.monmarad.gov.mn

2025.06.12. № 01/278
танай ____________-ны №____________-т

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА Б.БОЛОР-ЭРДЭНЭ ТАНАА

Монгол Улсын Далайн захиргааны 2025 оны хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 35 хуудастай.

ДАРГА Б.САЙНБАЯР

9... ТУ32165 Я 5592816

00000547

Засгийн газрын 2020 оны 206 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

# МОНГОЛ УЛСЫН ДАЛАЙН ЗАХИРГААНЫ 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв /төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хугацаа | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 1: Далайн болон усан замын тээврийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож, олон улсын стандартад нийцүүлэн боловсруулах** | | **Өөрийн эх үүсвэр** | **Олон улсын стандартад нийцүүлэн боловсруулсан баримт бичгийн тоо** | **0** | **1** | I-IV | | |
| 1.1 | Усан замын тээврийн тухай хуулийг шинэчлэх төслийн саналыг боловсруулж Зам, тээврийн яаманд хүргүүлэх | Өөрийн эх үүсвэр | Төслийг яаманд хүргүүлсэн эсэх Үгүй-2, Тийм-1 | 2 | Ажлын хэсэг байгуулах | I | Монгол Улсын Далайн захиргааны даргын 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/21 дүгээр тушаалаар ажлын хэсэг байгуулсан. Хуулийн төслийн санал боловсруулах хэлэлцүүлгийг 2025 оны 03 дугаар сарын 15-ны өдөр Зам тээврийн яамны болон орон дахь усан замын тээврийн хяналтын улсын /ахлах/ байцаагч нарыг оролцуулан зохион байгуулсан. | 100 |
| | | | | | Төсөл боловсруу-лах | II | Дээрх хэлэлцүүлгийн үеэр гаргасан саналыг хуулийн төсөлд тусгасан аргачлалын дагуу боловсруулсан. | 100 |
| | | | | | Санал авах | III | | |
| | | | | | Хүргүүлсэн байна. | IV | | |
| 1.2 | Монгол орны зарим нуурын эрэгт байгуулсан усан замын | Өөрийн эх үүсвэр | Тухайн онд хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | 0 | Хатгалын пост тохижуулах | II | Монгол Улсын Далайн захиргааны даргын 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн "Зардал гаргах тухай" | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тээврийн хяналтын пост тохижуулах | | | | | | А/44 дүгээр тушаалаар Хөвсгөл аймгийн Хатгал тосгон дахь "Хяналтын пост"-ын нийт 3 барилгын хана, дээвэр, шаланд дулаалга хийгдэж, доторлогоо, шалыг шинээр сольсон. Шаардлагатай тавилга, эд хогшлыг шинээр худалдан авах зардлыг Монгол Улсын Далайн захиргааны даргын 2025 оны 05 дугаар сарын 28-ний өдрийн А/72 дугаар тушаалаар баталсан. Хатгал, Ханх суман дахь хяналтын постуудад өөрийн дотоод нөөц боломжийг ашиглан бүрэн тохижуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. | |
| | | | | | Ханх, Өгий нуурын пост тохижуулах | III | | |
| 1.3 | Усан замын тээврийн салбарт шинээр нэвтрүүлэх шаардлагатай олон улсын стандартыг судлах, MNS стандарт нийцүүлэн боловсруулж, Зам, тээврийн яаманд хүргүүлэх | Өөрийн эх үүсвэр | Олон улсын стандартад нийцүүлэн боловсруулсан MNS стандартын тоо | 1 | Стандартыг судлах | I | Стандартчиллын олон улсын байгууллага (ISO)-ын стандартуудыг судалж, Бага оврын усан замын тээврийн хэрэгсэл-Ерөнхий өгөгдөл болон Бага оврын усан замын тээврийн хэрэгсэл-Өмчлөгчийн гарын авлага гэсэн 2 стандартыг сонгон холбогдох байгууллагаар дамжуулан худалдан авсан. | 100 |
| | | | | | Төсөл боловсруулах | II-III | Стандартуудын орчуулгыг баталгаат орчуулгын компаниар гэрээ байгуулан хийж гүйцэтгүүлсэн бөгөөд орчуулгын төслийг хянаж, Үндэсний стандарт боловсруулах MNS стандартад нийцүүлэх ажлыг хийж байна. | 100 |
| | | | | | Яаманд хүргүүлэх | IV | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.4 | Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, гэрчилгээ, улсын дугаар олгох журамд нэмэлт өөрчлөлт оруулах төслийн саналыг боловсруулж Зам, тээврийн яаманд хүргүүлэх | Өөрийн эх үүсвэр | Саналыг хүргүүлсэн эсэх Үгүй-2, Тийм-1 | 2 | Ажлын хэсэг байгуулах | I | Журамд нэмэлт өөрчлөлт оруулах төслийн санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Монгол Улсын Далайн захиргааны даргын 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/31 дүгээр тушаалаар байгуулаад байна. Ажлын хэсэг 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдөр хуралдаж, журмын төсөлд санал авах ажлыг зохион байгуулав. | 100 |
| | | | | | Төсөл боловсруулах | II | Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр журмын төсөлд санал авах хэлэлцүүлгийг зохион байгуулж, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулсан. | 100 |
| | | | | | Санал авах | III | | |
| | | | | | Яаманд хүргүүлэх | IV | | |
| 1.5 | Усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх журмын хэрэгжилтийг хангах, завь жолоодох эрхийн үнэмлэх олгох | Өөрийн эх үүсвэр | Тухайн онд завь жолоодох эрхийн үнэмлэх олгосон тоо | 20 | 7 | I | Тайлант хугацаанд нийт 3 иргэнд завь жолоодох эрхийн үнэмлэх олгосон.<br>Журмын хэрэгжилтийг хангах зорилгоор сургалтын үйл ажиллагаа эрхлэх байгууллагад тавигдах шаардлага, хууль эрх зүйн орчин, хөтөлбөрийн баталгаажуулалтын талаар мэдээлэл өгөх арга хэмжээг холбогдох төрийн бус байгууллагуудыг оролцуулан 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр Монгол Улсын Далайн захиргааны байранд зохион байгуулав. Энэхүү арга хэмжээний үр дүнд дахин нэг төрийн бус байгууллага сургалтын эрх авахаар хүсэлтээ холбогдох байгууллагад хүргүүлсэн байна. | 50 |
| | | | | | 14 | II | Хагас жилийн байдлаар нийт 10 иргэнд завь жолоодох эрхийн үнэмлэх олгосон. | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 20 | III | | |
| | | | | | 25 | IV | | |
| 1.6 | Олон улсын хөдөлмөрийн байгууллагын "Далайн хөдөлмөрийн тухай" конвенцын хэрэгжилтийн тайланг боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлэх | Өөрийн эх үүсвэр | Тухайн онд хийгдсэн тайлангийн тоо | 0 | Ажлын хэсэг байгуулах | I | Монгол Улсын Далайн захиргааны даргын 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/42 дугаар тушаалаар Олон улсын хөдөлмөрийн байгууллагын "Далайн хөдөлмөрийн тухай" конвенцын хэрэгжилтийн тайланг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. | 100 |
| | | | | | Тайлангийн төсөл боловсруулах | II | Ажлын хэсэг "Далайн хөдөлмөрийн тухай" конвенцын хэрэгжилтийн тайлангийн төслийг боловсруулсан. | 100 |
| | | | | | Удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэх | III | | |
| | | | | | Холбогдох байгууллагад хүргүүлэх | IV | | |
| 1.7 | "Далайн хөдөлмөрийн тухай" 2006 оны конвенцын 2022 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн орчуулгыг Зам тээврийн яаманд хүргүүлэн нэгдэн ороход дэмжлэг үзүүлэн ажиллах | Өөрийн эх үүсвэр | Тухайн онд хийгдсэн орчуулгын төсөл | 0 | Төслийг боловсруулах | I | Зам, тээврийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газарт Монгол Улсын Далайн захиргааны даргын 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 01/105 тоот албан бичгээр "Далайн хөдөлмөрийн тухай" 2006 оны конвенцын 2022 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн танилцуулгын орчуулгын хамт хүргүүлсэн. | 100 |
| | | | | | Яаманд хүргүүлэх | II | Монгол Улсын Далайн захиргаанаас 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 01/105 тоот албан бичгээр Зам, тээврийн яаманд хүргүүлсэн. | 100 |
| **Зорилт 2: Далайн болон усан замын тээврийн үйл ажиллагааг чанаржуулах** | | **Өөрийн эх үүсвэр** | **Хэрэглэгчийн үнэлгээний дундаж хувь** | **0** | **50** | **I-IV улирал** | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Хяналт шалгалт хийсэн хөлөг онгоцны тоо | 21 | 10 | I | 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэлтэй нийт 13 хөлөг онгоцонд далбааны эзэн улсын хяналт шалгалтыг явуулсан. Сингапур, Индонез улсад 5 хөлөг онгоц, Тайвань улсад 7 хөлөг онгоцыг далбааны эзэн улсын хяналтын улсын байцаагч явуулсан бол гэрээт хянан шалгагч 1 хөлөг онгоц дээр Индонез улсад үзлэг, хяналт шалгалт явуулсан. | 100 |
| | | | 15 | II | Хагас жилийн байдлаар Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэлтэй нийт 18 хөлөг онгоцонд далбааны эзэн улсын хяналт шалгалтыг явуулсан. Сингапур, Индонез улсад 5 хөлөг онгоц, Тайваньд 7 хөлөг онгоц, БНСУ-д 5 хөлөг онгоцонд далбааны эзэн улсын хяналтын улсын байцаагч, Индонез улсад гэрээт хянан шалгагч 1 хөлөг онгоц дээр үзлэг, хяналт шалгалт явуулсан. Хяналт шалгалтын тайланг 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 01/120 тоот албан бичиг, 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 01/241 тоот албан бичиг, 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 01/245 тоот албан бичгээр тус тус Зам, тээврийн яаманд хүргүүлсэн. | 100 |
| | | | 20 | III | | |
| | | | 25 | IV | | |
| | Гэрээт хянан шалгагчийн тоо | 3 | 1 | I | Байгууллагын цахим хуудаст зар мэдээ байршуулсаны дагуу цахим шуудангаар хянан шалгагчаар хамтран ажиллах 4 хүсэлт ирүүлээд байна. Эдгээр хянан шалгагчидтай цахим шуудангаар холбоо тогтоон 1 | 30 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дүгээр улирлын байдлаар 1 хянан шалгагчид хамтран ажиллах гэрээний төслийг хүргүүлэн санал авч гэрээний төсөлд өөрчлөлт оруулан хамтран ажиллах бэлтгэл ажил хийгдэж байна. | |
| | | | | | 2 | II | Далбааны эзэн улсын гэрээт хянан шалгагчийн тоог нэмэгдүүлэх үүднээс хамтран ажиллах хүсэлт ирүүлсэн хянан шалгагчидтай хамтран ажиллах гэрээ байгуулахаар гэрээний төсөлд санал авч хагас жилийн байдлаар 3 гэрээт хянан шалгагчидтай хамтран ажиллах гэрээ байгуулахаар санал солилцон ажиллаж байна. | 50 |
| | | | | | 3 | III | | |
| | | | | | 5 | IV | | |
| 2.3 | Усан замын тээврийн хэрэгслийн 2025 оны техникийн хяналтын үзлэг, тооллогыг зохион байгуулах | Өөрийн эх үүсвэр | Хяналтын үзлэг тооллогыг зохион байгуулсан эсэх Үгүй-2, Тийм-1 | 2 | 1 | III | Монгол Улсын Далайн захиргааны даргын 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/77 дугаар тушаалаар усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, тооллого, хяналт шалгалтыг орон нутагт зохион байгуулахаар шийдвэрлэсэн. | 100 |
| 2.4 | Усан замын тээврийн ажил, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх | Өөрийн эх үүсвэр | Хяналт шалгалтын тайланг хүргүүлсэн эсэх Үгүй-2, Тийм-1 | 2 | Хяналт шалгалт зохион байгуулах | II-III | Зам, тээврийн сайдын 2025 оны А/10 дугаар тушаалаар хяналтын шалгалтад хамрагдах аж ахуйн нэгж, иргэдийн жагсаалтыг батлуулсан. Монгол Улсын Далайн захиргааны даргын 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/77 дугаар тушаалаар усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, тооллого, хяналт шалгалтыг орон нутагт зохион байгуулахаар шийдвэрлэсэн. | 100 |
| | | | | | Тайлан хүргүүлэх | IV | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.5 | Усан замын тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгуулах баримт бичгийн бүрдлийг хүлээн авах, шалгах, хүсэлтийг шийдвэрлэх | Өөрийн эх үүсвэр | Тусгай зөвшөөрөл олголтын тоо | 36 | 10 | I | Тайлант хугацаанд нийт 3 иргэний тусгай зөвшөөрөл шинээр авах хүсэлтийг цахимаар хүлээн авсан бөгөөд баримт бичгийн бүрдлийг шалгаж, ажлын хэсгийн нэгдсэн дүгнэлт, Зам, тээврийн сайдын тушаалын төслийг боловсруулж, хүсэлтийг шийдвэрлэхээр Зам, тээврийн Яаманд тус тус хүргүүлээд байна. | 30 |
| | | | | | 20 | II | Тайлант хугацаанд нийт 17 иргэний тусгай зөвшөөрөл авах хүсэлтийг цахимаар хүлээн авсан бөгөөд Ажлын хэсэгт ирүүлсэн баримт бичгийг хянан үзэж, шаардлага хангасан 8 иргэний хүсэлтийг дүгнэлтийн хамт ЗТЯ-нд тус тус хүргүүлсэн. | 40 |
| | | | | | 30 | III | | |
| | | | | | 40 | IV | | |
| **Зорилт 3:“Хуурай боомтын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т тусгагдсан байршлуудад хуурай боомтыг үе шаттай байгуулах** | | **Өөрийн эх үүсвэр** | **Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь** | **0** | **70** | I-IV улирал | | |
| 3.1 | “Хуурай боомтын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн хүрээнд Дорноговь аймгийн Замын-Үүд суман дахь “Бүс нутгийн логистикийн төв”-ийг түшиглэн олон улсын чанартай хуурай боомт байгуулах ажлыг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх | Өөрийн эх үүсвэр | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | **0** | 12 | I | Дорноговь аймгийн Замын-Үүд суман дахь “Бүс нутгийн логистикийн төв (БНЛТ)”-ийг түшиглэн олон улсын чанартай хуурай боомт байгуулах ажлыг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө” боловсруулж, 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр баталсан. Төлөвлөгөөний хүрээнд дараах ажлуудыг авч хэрэгжүүлэв. Үүнд:<br>-Замын-Үүд суман дахь БНЛТ-ийн талбайг ашиглах талаар зах зээлийн тооцоо, судалгаа хийж гүйцэтгэсэн. Уг судалгааны хүрээнд БНЛТ-д 2025 оны 01 дүгээр сарын 22-23-ны | **100** |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өдрүүдэд томилолтоор газар дээр нь ажиллаж "МТЗ" ТӨХК болон "УБТЗ" ХНН-ийн Замын-Үүдийн шилжүүлэн ачих ангийн дарга болон холбогдох албаны хүмүүстэй уулзалт хийсэн.<br>-БНЛТ-ийг түшиглэн авто машинаар тээвэрлэж буй импортын ачаа барааг боловсруулах, зам талбай, дэд бүтэц, барилга байгууламжийг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар хуурай боомтын үйл ажиллагааг эхлүүлэх дүгнэлт, саналыг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Зам, тээврийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/50 дугаар тушаалаар байгуулан ажилласан ба дараах чиглэлээр ажлууд хийгдсэн болно. Үүнд:<br>- Импортын ачаа тээврийг оновчтой, үр ашигтай зохион байгуулж, олон төрөлт тээвэр зохион байгуулалтыг сайжруулах<br>-БНЛТ-ийн ашиглалтын үйл ажиллагааг сайжруулж эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх<br>-БНХАУ-ын далайн боомт дахь Монгол Улсын импортын ачааны бөөгнөрлийг бууруулах зэрэг болно. | |
| | | | | | 25 | II | Ажлын хэсгийн дүгнэлт, саналыг боловсруулан 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 01/189 тоот албан бичгээр Зам, тээврийн сайдад хүргүүлсэн. Мөн санал дүгнэлтэд үндэслэн үйл ажиллагааг эхлүүлэн ажиллах талаар холбогдох шийдвэр гаргуулахаар "Чиглэл өгөх тухай" албан бичгийн төслийг боловсруулан уг бичгийн хавсралтаар хүргүүлсэн болно. "Дорноговь аймгийн Замын-Үүд | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | суман дахь Бүс нутгийн логистикийн төвийг түшиглэн олон улсын чанартай хуурай боомт байгуулах ажлыг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө"-нд нийт 10 ажил тусгагдсан бөгөөд хэрэгжилт 53%-тай байна. | |
| | | | | | 37 | III | | |
| | | | | | 50 | IV | | |
| 3.2 | Монгол Улсын Засгийн газраас өгсөн олон улсын хуурай боомт байгуулах чиглэлээр эрчимтэй ажиллах чиг үүргийн дагуу Монгол Улсад олон улсын хуурай боомт байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтын асуудлыг судалж гадаад улс орнуудын дэмжлэг авч төр хувийн хэвшлийн түншлэлийг хангах үүрэг бүхий Ерөнхий сайдын 2023 оны 111 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах | Өөрийн эх үүсвэр | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 30 | 40 | I-II | Ажлын хэсгийн батлагдсан төлөвлөгөөний биелэлтийг боловсруулж, үнэлгээ хийсэн ба Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 111 дүгээр захирамжийн хүрээнд Монгол Улсын Далайн захиргааны хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдөр боловсруулж батлуулсан болно. Батлагдсан төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:<br>-НҮБ-ын АНДЭЗНК-ын "Хуурай боомтын тухай" Засгийн газар хоорондын хэлэлцээрийн 1 дүгээр хавсралтад нэмэлт өөрчлөлт орсныг хянан баталгаажуулахаар Зам, тээврийн яаманд хүргүүлсний дагуу Зам, тээврийн яамнаас ХЗДХЯ, ГХЯ-нд хүргүүлж, холбогдох хариу хүлээгдэж байна.<br>-Хуурай боомтын хөрөнгө оруулалт татах ажлын хүрээнд Дэлхийн банкны санхүүжилтээр "Замын-Үүд хуурай боомтын ТЭЗҮ боловсруулах тухай" хурал Зам, тээврийн яаманд 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулагдсан ба холбогдох судалгаа, авч хэрэгжүүлсэн ажлын тухай танилцуулгыг хийж ажилласан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | -НҮБ-ын АНДЭЗНК-оос 2025 оны 03 дугаар сарын 26-27-ны өдрүүд Тайланд Улсын Бангкок хотноо зохион байгуулагдсан "Хуурай боомтын үйл ажиллагаа, логистик болон олон төрөлт тээврийн үйлчилгээнд оролцогч талуудын форум"-д илтгэл тавьж, хууль эрх зүйн орчны талаар туршлага судлах, техникийн туслалцаа авах талаарх хүсэлтийг гаргаж ажилласан..<br>-НҮБ-ын АНДЭЗНК-оос эрхлэн гаргасан Төр хувийн хэвшлийн түншлэлийн амжилттай хэрэгжсэн олон улсын жишээ, туршлагыг орчуулсан. | |
| | | | | | 50 | II | Хуурай боомт байгуулах байршил болон газрын асуудлаар Дорноговь аймаг, Говьсүмбэр аймаг болон "Хүннү смарт хот"-ын холбогдох албаны хүмүүстэй уулзаж хамтран ажиллаж байна.<br>Олон улсын чанартай хуурай боомтын үндэсний стандарт боловсруулах ажлын хэсгийг 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/47 дугаар тушаалаар байгуулсан бөгөөд БНХАУ, Сингапур Улс, БНСУ-ын холбогдох хууль, стандартуудыг орчуулан судалж, үндэсний стандартын төслийг боловсруулж эхэлсэн.<br>2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 01/247 тоот албан бичгээр Дорноговь аймгийн Засаг даргад Сайншанд хотод хуурай боомт байгуулах боломжтой хоёр байршлын нэгдүгээр хувилбарыг орон нутгийн тусгай хэрэгцээнд | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шилжүүлэн авах хүсэлтийг хүргүүлсэн.<br>-"Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 111 дүгээр захирамжийн хүрээнд Монгол Улсын Далайн захиргааны хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө"-нд нийт 24 ажил тусгагдсан бөгөөд хэрэгжилт 68.7%-тай байна. | |
| | | | | | 60 | III | | |
| | | | | | 80 | IV | | |
| 3.3 | Буйр нуурт усан замын боомт байгуулах чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллах | Өөрийн эх үүсвэр | Ажлын хэсгийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хувь | 0 | 12 | I | "Улирлын чанартай Буйр нуур усан замын боомт байгуулах" үүрэг бүхий ажлын хэсэг Зам, тээврийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/259 дугаар тушаалаар байгуулагдаж төлөвлөгөө батлан холбогдох ажлуудыг хэрэгжүүлэн ажилласан. Хилийн боомтын захиргаанаас ирүүлсэн 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 01/09 тоот албан бичгийн хүсэлтийн дагуу "Буйр нуур усан замын улирлын чанартай боомт байгуулах ТЭЗҮ боловсруулах ажлын даалгавар"-т холбогдох санал өгөх, мөн үнэлгээний хороонд орж ажиллах ажилтнуудын мэдээллийг 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 01/09 тоот албан бичгээр хариу хүргүүлсэн. | 100 |
| | | | | | 25 | II | Холбогдох ажлын хэсгийн гишүүдийн саналыг үндэслэн нэгдсэн дүгнэлтийг гарган Боомтын сэргэлтийн үндэсний хороонд хүргүүлэх албан бичгийн төслийн хамтаар 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 01/190 тоот албан бичгийг Зам, тээврийн сайдад хүргүүлсэн. Улирлын чанартай Буйр нуур усан замын боомт байгуулах | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үүрэг бүхий ажлын хэсгийн төлөвлөгөөнд нийт 8 ажил тусгагдсан ба 91%-тай гүйцэтгэсэн. *Энэхүү ажлын хэсэг төлөвлөгөөний дагуу ажлуудаа гүйцэтгэж дууссан тул хяналтаас хасуулах саналтай байна.* | |
| | | | | | 37 | III | | |
| | | | | | 50 | IV | | |
| 3.4 | "Хуурай боомтын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийн хүрээнд Замын-Үүд, Улаанбаатар байршлуудад эхлэл цэг болох далайн боомтуудтай харилцаа тогтоож, хамтын ажиллагааг бэхжүүлэх | Өөрийн эх үүсвэр | Хамтын ажиллагааг эхлүүлж чадсан эсэх<br>Үгүй-2, Тийм-1 | 2 | Харилцаа тогтоох боомтуудыг жагсаалтаар гаргах | I-II | Замын-Үүд, Улаанбаатар байршлуудад эхлэл цэг болох далайн боомтуудтай харилцаа холбоо тогтоохоор БНХАУ-ын далайн боомтуудыг хуурай боомтын эхлэл болгоход тавих шалгуур үзүүлэлт болон боомтуудын үнэлгээний судалгааны ажлыг хийж гүйцэтгэж, холбогдох жагсаалтыг гаргасан болно. Одоогийн байдлаар БНХАУ-ын Жинжоу болон Далянь боомтуудтай харилцаа холбоотой ажилладаг бөгөөд Тяньжин, Чиньхундао, Цаофэйдянь, Инкоу, Дандун далайн боомтуудтай харилцаа холбоо нягт тогтоохоор ажиллаж байна.<br>БНХАУ-ын Шаньдун мужийн Рижао далайн боомттой хамтран ажиллах, судалгаа хийх, холбогдох байгууллагуудтай уулзалт зохион байгуулж, санал солилцох зорилгоор Монгол Улсын Далайн захиргааны дарга 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдрөөс 16-ны өдрүүдэд томилолтоор тус боомтод ажилласан.<br>Мөн 2025 оны 8,9 дүгээр сард Далайн захиргааны төлөөлөл нэр дурдагдсан боомтууд руу очиж, холбогдох хамтын ажиллагааны | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тухай албан уулзалт зохион байгуулж ажиллахаар төлөвлөөд байна.<br>2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр БНХАУ-ын судлаач Др.Би Делитэй Монгол Улсын Далайн захиргааны төлөөлөл уулзаж санал солилцсон.<br>2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр "Монложистик" ХХК-тай автомашиныг задгайгаар тээвэрлэх туршилтын тээврийг хамтарч гүйцэтгэх талаар ээлжит уулзалтыг зохион байгуулсан.<br>Уул уурхайн бүтээгдэхүүнийг Замын-Үүд, Сайншанд, Чойр хуурай боомтуудаар нэгтгэн зохион байгуулах нөхцөл боломжийн судалгааг хийж гүйцэтгэн Зам, тээврийн яаманд хүргүүлэхээр бэлтгэж байна. | |
| | | | | | Уулзалт зохион байгуулах | III-IV | | |
| 3.5 | БНХАУ-ын Ляонин мужийн Далянь болон бусад далайн боомтуудаас ачаа тээвэрлэлтийг эхлүүлэх чиглэлээр арга хэмжээ авч ажиллах | Өөрийн эх үүсвэр | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 50 | 60 | I | Монгол Улсын импортын автомашиныг задгайгаар тээвэрлэн Далянь боомтоор дамжуулан тусгай зориулалтын тээврийн хэрэгсэлд шилжүүлэн ачиж, Замын-Үүд-Эрээн боомтоор нэвтрүүлэх туршилтын тээврийн ажлыг эхлүүлэх талаар Далянь боомт болон Ляонин мужийн холбогдох байгууллагуудтай цахимаар мэдээлэл солилцож хамтарч ажиллаж байна.<br>"Туршилтын тээвэрлэлтийг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөө"-г боловсруулж 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр баталсан.<br>Туршилтын тээврийг эхлүүлэх явцад БНХАУ-ын Гаалийн байгууллагаас | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | автомашиныг задгайгаар тээвэрлэх нь шаардлагад нийцэхгүй байгаа талаар мэдэгдсэн. Уг асуудлыг шийдвэрлэх хүрээнд албан хүсэлтүүдийг гаргаж, холбогдох байгууллагуудтай санал солилцох уулзалтуудыг хийж ажиллав. Үүнд:<br>-ГЕГ-т БНХАУ-ын гаалийн байгууллагаас тодруулга авах хүсэлтийг 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 01/15 тоот албан бичгээр;<br>-БНХАУ-ын ГЕГ-тай холбогдох асуудлыг хэлэлцэж, шийдвэрлүүлэх талаар уулзалт зохион байгуулах хүсэлтийг Зам, тээврийн яаманд 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 01/13 тоот албан бичгээр ;<br>-2025 оны 01 дүгээр сарын 20,28-ны өдрүүдэд “МТЗ” ТӨХК-тай Замын-Үүдийн БНЛТ-д импортын автомашин хүлээн авах, хамтарч ажиллах боломжийн талаарх хэлэлцэх уулзалт;<br>-2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр ГЕГ-тай автомашин задгайгаар тээвэрлэхэд хориг саад байгаа эсэх талаар тодруулж, БНЛТ-өөр автомашин буулгах асуудалд хамтарч ажиллах боломжийн талаар санал солилцсон;<br>-2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр Замын-Үүдийн “БНЛТ”-д “УБТЗ”-ХНН-ийн төлөөлөлтэй импортын автомашин хүлээж авах, буулгах талаар санал солилцсон.<br>-2025 оны 02 дугаар сарын 11-ний өдөр “МТЗ” ТӨХК-ийн гишүүн байгууллага болох “Монложистик”, “Туушин” ХХК-тай туршилтын тээврийг хамтарч гүйцэтгэх талаарх уулзалтыг хийсэн. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | -2025 оны 02 дугаар сарын 17-ны өдөр болон 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр “Монложистик” ХХК-тай туршилтын тээврийн талаар уулзалт зохион байгуулсан.<br>Мөн 2025 оны 2 дугаар улиралд зохион байгуулагдах Монгол, БНХАУ-ын хилийн дэглэмийн хамтарсан комиссын VI хуралдаанд Монгол Улсын Далайн захиргааны төлөөллийг оролцуулах, тус хуралдааны хэлэлцэх асуудалд үүсээд буй асуудлыг шийдвэрлүүлэхээр холбогдох саналыг тусгуулах хүсэлтийг Хилийн боомтын захиргаанд 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 01/115 тоот албан бичгээр хүргүүлсэн. | |
| | | | | | 70 | II | 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр БНХАУ-ын судлаач Др.Би Делитэй Монгол Улсын Далайн захиргааны төлөөлөл уулзаж холбогдох асуудлыг шийдвэрлэх боломжийн талаар лавлаж асуухад хоёр улсын өндөр дээд хэмжээний айлчлалын хүрээнд асуудлыг дэвшүүлж хөндөж ярилцах замаар шийдвэрлүүлэх нь илүү үр дүнтэй гэсэн хариу өгөөд байна.<br>2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрүүдэд “Монложистик” ХХК-тай автомашиныг задгайгаар тээвэрлэх туршилтын тээврийг хамтарч гүйцэтгэх талаар ээлжит уулзалтыг зохион байгуулсан. Тус компанийн БНХАУ-ын талын хамтрагчид тус улсын гаалийн байгууллагаас шаардлагад нийцэхгүй байгаа тухай бичгийг хүлээн авснаас хойш туршилтын тээврийг үргэлжлүүлэхээс татгалзсан болно. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Уул уурхайн бүтээгдэхүүнийг Замын-Үүд, Сайншанд, Чойр хуурай боомтуудаар нэгтгэн зохион байгуулах нөхцөл боломжийн судалгааг хийж гүйцэтгэн Зам, тээврийн яаманд хүргүүлэхээр бэлтгээд байна. "Туршилтын тээвэрлэлтийг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөө"-нд нийт 8 ажил тусгагдсан бөгөөд хэрэгжилт 70%-тай байна. | |
| | | | | | 80 | III | | |
| | | | | | 100 | IV | | |
| 3.6 | Олон улсын хуурай боомтын төлөвлөлт, бүтээн байгуулалтын чиглэлээр сайн туршлагыг нэвтрүүлэх чиглэлээр үе шаттай арга хэмжээ авч ажиллах | Өөрийн эх үүсвэр | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 50 | 60 | I | БНХАУ-ын "Шанхай Винжоин" мэдээлэл технологийн компанитай холбоо тогтоож, туршлага судлах албан уулзалтыг зохион байгуулах зорилгоор 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 01/75 тоот албан бичгийг хүргүүлсэн.<br>2025 оны 02 дугаар сарын 24-ний өдөр "Шанхай Винжоин" мэдээлэл технологийн компанийн ТУЗ-ийн дарга Ву Жүнфэн, дэд ерөнхий захирал Шэн И нартай уулзалт хийж, Монгол Улсын эдийн засгийн тогтвортой, урт хугацааны хөгжлийг дэмжих, ухаалаг хуурай боомтын бүтээн байгуулалт болон хийж хэрэгжүүлсэн төслүүдийн талаар хэлэлцсэн.<br>Монгол Улсын Далайн захиргааны дарга Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсад 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрөөс 21-ний өдрүүдэд айлчлах үеэрээ Хай Фонг олон улсын чингэлгийн далайн боомтын бүтээн байгуулалт, үйл ажиллагааны чиглэл, сайн туршлагатай танилцсан болно. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Дэлхийн яаралтай авран туслах байгууллагатай хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичгийг 2024 онд байгуулсан. Энэхүү санамж бичгийн хүрээнд 2025 онд бүс нутгийн худалдаа, тээврийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх, БНХАУ-ын хуурай боомтын хөгжлийн сайн туршлагаас суралцах, хуурай боомт, далайн боомттой холбоо тогтоох болон хуурай боомтын мэргэжилтнүүдийн чадавхыг дээшлүүлэх тусгай сургалтыг 2 үе шаттайгаар хамтран зохион байгуулах чиглэлээр 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр сургалтын хөтөлбөр боловсруулан хамтран ажиллах тухай 01/69 дүгээр албан бичиг хүргүүлсэн. Тус байгууллагаас Монгол Улсад шаардлагатай сургалтын хэрэгцээг тодорхойлж холбогдох сургалтын хөтөлбөр боловсруулж ирүүлээд байна.<br>Монгол Улсын Далайн захиргааны Далайн тээвэр, хуурай боомтын хэлтсийн "Хуурай боомт болон далайн боомтын холболтын чиглэлээр байгуулсан санамж бичгийн хүрээнд 2025 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө" мөн "2025 оны сургалтын төлөвлөгөө"-г боловсруулан 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр баталсан. | |
| | | | | | 70 | II | БНСУ-ын Далайн хэрэг, загас агнуурын яамны урилгаар "Бидний далай 2025" олон улсын хуралд Монгол Улсын Далайн захиргааны төлөөлөл оролцсон ба тус улсын "Логистикийн байгууламжийн хөгжүүлэлт, удирдлагын тухай" хуулийн талаар болон бусад | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | холбогдох судалгааг хийж ажилласан.<br>БНХАУ, Сингапур Улс, БНСУ, Европын холбогдох стандарт, эрх зүйн орчны талаар орчуулан судалсан.<br>БНХАУ-ын Шаньдун мужийн Рижао далайн боомттой хамтран ажиллах, судалгаа хийх, холбогдох байгууллагуудтай уулзалт хийж санал солилцох зорилгоор Монгол Улсын Далайн захиргааны дарга 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдрөөс 16-ны өдрүүдэд томилолтоор тус боомтод ажиллаж туршлага судалсан.<br>НҮБ-ын АНДЭЗНК-аас Хойд, Төв Азийн дэд бүс болон Монгол Улсад зориулан зохион байгуулсан "Хуурай боомтууд болон тэдгээрийг олон төрлийн тээврийн сүлжээнд нэгтгэх цахим хэрэгслүүдийн хөгжүүлэлт" сэдэвт мэдлэг дээшлүүлэх семинарт 2025 оны 06 дугаар сарын 10-11-ний өдрүүдэд Монгол Улсын Далайн захиргааны төлөөлөл цахимаар хамрагдсан.<br>"Хуурай боомт болон далайн боомтын холболтын чиглэлээр байгуулсан санамж бичгийн хүрээнд 2025 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө"-нд нийт 4 ажил тусгагдсан бөгөөд хэрэгжилт 70%-тай байна. Мөн "2025 оны сургалтын төлөвлөгөө"-нд нийт 6 ажил тусгагдсан бөгөөд хэрэгжилт 70%-тай байгаа болно. | |
| | | | | | 80 | III | | |
| | | | | | 100 | IV | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
